

□
ХҮНС, ХӨДӨӨ АЖ АХУЙ, ХӨНГӨН ҮЙЛДВЭРИЙН САЙД, САНГИЙН САЙДЫН ХАМТАРСАН

ТУШААЛ

2019 оны 12 дугаар сарын 26-ны өдөр

Дугаар 290/А-504

Улаанбаатар хот

ЖУРАМ БАТЛАХ ТУХАЙ

Тариалангийн тухай хуулийн 19 дүгээр зүйлийн 19.6 дахь хэсгийг үндэслэн ТУШААХ нь:

- 1.Тариалангийн үйлдвэрлэл эрхэлж байгаа иргэн, хуулийн этгээдийн үйлдвэрлэсэн бүтээгдэхүүнд мөнгөн урамшуулал олгох, мөнгөн бус дэмжлэг үзүүлэх журам"-ыг хавсралт ёсоор баталсугай.
- 2.Журмын хэрэгжилтэд хяналт тавьж ажиллахыг Хүнс, хөдөө аж ахуй, хөнгөн үйлдвэрийн яам, Сангийн яамны Төрийн нарийн бичгийн дарга нарт үүрэг болгосугай.
- 3.Энэ тушаал гарсантай холбогдуулан Журам батлах тухай Хүнс, хөдөө аж ахуй, хөнгөн үйлдвэрийн сайд, Сангийн сайдын 2010 оны 2 дугаар сарын 9-ний өдрийн 24/34 дүгээр хамтарсан тушаалыг хүчингүй болсонд тооцсугай.

ХҮНС, ХӨДӨӨ АЖ АХУЙ, ХӨНГӨН ҮЙЛДВЭРИЙН САЙД Ч.УЛААН
САНГИЙН САЙД Ч.ХҮРЭЛБААТАР